

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/01/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан	15
3.1 Ерөнхий зүйл	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
НДЕГ	Нийгмийн даатгалын Ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/67
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020263

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,737,420,360.26	18,343,379,120.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,570,573,463.78	11,622,911,732.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,570,573,463.78	11,622,911,732.19
3121	Төгрөг	8,570,573,463.78	11,622,911,732.19
31211	Төрийн сангийн харилцах	9,478,725.17	233,410.43
31213	Арилжааны банк дахь харилцах	8,561,094,738.61	11,622,678,321.76
33	АВЛАГА	5,143,701,612.64	6,706,127,911.55
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	894,262,122.66	1,448,509,979.73
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,047,912,028.37	4,812,277,201.02
335	Бусад авлага	201,527,461.61	445,340,730.80
3351	Байгууллагаас авах авлага	201,527,461.61	445,340,730.80
35	БАРАА МАТЕРИАЛ	23,145,283.84	14,339,476.66
354	Хангамжийн материал	23,145,283.84	14,339,476.66
35410	Бичиг хэргийн материал	377,216.91	388,400.01
35420	Аж ахуйн материал	19,579,377.67	10,082,067.67
35430	Сэлбэг хэрэгсэл	872,600.00	1,899,500.00
35470	Бусад хангамжийн материал	2,316,089.26	1,969,508.98
2	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	584,040,984.27	574,144,592.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	584,040,984.27	574,144,592.21
392	Биет хөрөнгө	562,240,984.27	549,143,990.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	529,621,659.99	529,621,659.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,693,121.00)	(33,709,319.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	12,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,544,700.00)	(391,922.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	182,971,430.15	147,305,545.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,711,152.20)	(121,792,637.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,851,435.40	44,775,886.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,254,568.07)	(28,965,222.67)
393	Биет бус хөрөнгө	21,800,000.00	25,000,602.00
39301	Програм хангамж	3,200,602.00	3,200,602.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,200,602.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	21,800,000.00	21,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,321,461,344.53	18,917,523,712.61

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>699,523,755.67</u>	<u>1,086,241,461.07</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	699,523,755.67	1,086,241,461.07
413	Өглөг	392,711,045.62	581,134,840.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,466,903.14
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	392,711,045.62	578,667,937.33
414	Урьдчилж орсон орлого	306,812,710.05	505,106,620.60
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	306,812,710.05	505,106,620.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>13,621,937,588.86</u>	<u>17,831,282,251.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	13,621,937,588.86	17,831,282,251.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	339,724,535.61	339,724,535.61
512	Хуримтлагдсан үр дүн	13,116,273,021.86	17,325,617,684.54
51210	Өмнөх үеийн үр дүн	3,536,477,835.60	13,125,937,829.24
51220	Тайлант үеийн үр дүн	9,579,795,186.26	4,199,679,855.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,940,031.39	165,940,031.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>14,321,461,344.53</u>	<u>18,917,523,712.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	139,494,025,949.63	135,546,854,304.53
11	ТАТВАРЫН ОРЛОГО	34,192,049,616.18	38,147,525,114.09
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	34,192,049,616.18	38,147,525,114.09
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,658,087,613.25	27,778,100,917.16
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,295,959,922.71	2,449,185,487.47
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,614,583,923.30	1,738,840,826.63
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	414,494,120.89	457,022,648.15
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,208,924,036.03	5,724,375,234.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,536,243.85	94,705,938.75
120	Нийтлэг татварын бус орлого	180,536,243.85	70,315,227.75
120002	Хүүгийн орлого	143,508,408.04	24,321,904.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,124,596.81	39,220,864.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,541,996.61	38,375,864.89
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,582,600.20	845,000.00
120009	Бусад орлого	24,903,239.00	6,772,458.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		24,390,711.00

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,121,440,089.60	97,304,623,251.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	196,000,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,000,000.00	
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх□	196,000,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,851,000.00	485,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,851,000.00	285,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	104,021,540,789.60	96,427,669,251.69
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,021,540,789.60	96,427,669,251.69
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	900,048,300.00	876,469,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	900,048,300.00	876,469,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	129,914,230,763.37	131,349,183,437.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	918,390,797.84	909,582,556.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,390,797.84	909,582,556.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649,371,100.00	650,544,617.80
210101	Үндсэн цалин	496,177,507.00	490,058,920.00
210102	Нэмэгдэл	118,351,997.22	129,191,697.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,321,598.55	19,844,000.00
210104	Урамшуулал	11,519,997.23	11,450,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,752,347.00	85,753,292.90
210201	Тэтгэврийн даатгал	55,394,421.07	59,332,703.37
210202	Тэтгэмжийн даатгал	6,843,619.10	6,603,003.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,469,930.14	5,282,402.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,413.73	1,320,600.71
210205	Эрүүл мэндийн даатгал	13,678,962.96	13,214,582.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,278,190.00	42,244,866.00
210301	Гэрэл, цахилгаан	3,458,706.00	3,448,702.00
210302	Түлш, халаалт	37,377,560.00	37,377,560.00
210303	Цэвэр, бохир ус	1,441,924.00	1,418,604.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,827,998.17	43,706,976.90
210401	Бичиг хэрэг	6,588,883.09	7,425,916.90
210402	Тээвэр, шатахуун	17,887,900.00	17,887,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,844,641.08	5,172,470.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,266,574.00	12,630,690.00

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,161,410.00	1,473,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	707,210.00	473,100.00
210604	Урсгал засвар	2,454,200.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,096,000.00	2,782,500.00
210702	Дотоод албан томилолт	3,096,000.00	2,782,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,179,134.57	41,203,780.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,843,184.58	25,628,625.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,785,600.00	1,785,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,900.00	60,900.00
210807	Газрын төлбөр	65,325.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,211,700.00	9,088,190.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,654,424.99	4,025,140.28
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,724,618.10	41,873,422.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,200.00	1,997,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,982,418.10	39,876,322.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,995,839,965.53	130,439,600,881.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,109,153,544.00	76,394,872,617.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	72,059,114,244.00	76,371,856,217.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,683,500.00	7,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,355,800.00	15,516,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,886,686,421.53	54,044,728,264.11
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,886,686,421.53	54,044,728,264.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>9,579,795,186.26</u>	<u>4,197,670,867.30</u>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	2,008,988.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,579,795,186.26</u>	<u>4,199,679,855.30</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	3,521,340,582.57	4,027,005,149.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,137,253.03	15,137,253.03
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	3,536,477,835.60	4,042,142,402.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,579,795,186.26	9,579,795,186.26
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	13,116,273,021.86	13,621,937,588.86
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	13,116,273,021.86	13,621,937,588.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,664,807.39	9,664,807.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	13,125,937,829.25	13,631,602,396.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	4,199,679,855.30	4,199,679,855.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	17,325,617,684.55	17,831,282,251.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	135,511,706,328.05	134,735,569,529.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	30,295,660,069.85	37,024,558,426.55
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	30,295,660,069.85	37,024,558,426.55
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,610,238,005.89	27,242,218,255.38
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,904,562,827.41	2,202,209,486.56
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,253,945,720.94	1,509,273,570.61
112004	Ажигүйдлийн даатгалын шимтгэл	353,780,017.63	410,785,914.98
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,173,133,497.98	5,660,071,199.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	325,744,673.20	355,254,821.61
120	Нийтлэг татварын бус орлого	325,744,673.20	355,254,821.61
120002	Хүүгийн орлого	143,508,408.04	24,321,904.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,236,265.16	330,932,916.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,653,664.96	330,087,916.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,582,600.20	845,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,890,301,585.00	97,355,756,281.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		59,067,320.45
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		59,067,320.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,851,000.00	485,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,851,000.00	285,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	103,986,402,285.00	96,419,734,960.69
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,986,402,285.00	96,419,734,960.69
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	900,048,300.00	876,469,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	900,048,300.00	876,469,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	129,846,811,609.91	131,683,231,260.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	861,019,597.66	856,446,975.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	861,019,597.66	856,446,975.57

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649,371,100.00	650,540,007.57
210101	Үндсэн цалин	515,185,914.34	492,068,029.57
210102	Нэмэгдэл	99,343,589.88	123,700,378.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,321,598.55	23,321,600.00
210104	Урамшуулал	11,519,997.23	11,450,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,752,347.00	83,291,000.00
210201	Тэтгэврийн даатгал	55,394,421.07	57,662,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,843,619.10	6,407,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,469,930.14	5,125,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,413.73	1,281,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,678,962.96	12,814,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,278,190.00	42,244,866.00
210301	Гэрэл, цахилгаан	3,458,706.00	3,448,702.00
210302	Түлш, халаалт	37,377,560.00	37,377,560.00
210303	Цэвэр, бохир ус	1,441,924.00	1,418,604.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,357,041.08	34,070,850.00
210401	Бичиг хэрэг	6,685,300.00	7,437,100.00
210402	Тээвэр, шатахуун	17,887,900.00	17,887,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,844,641.08	5,172,470.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,699,200.00	2,983,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,324,510.00	2,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	870,310.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	2,454,200.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,096,000.00	2,782,500.00
210702	Дотоод албан томилолт	3,096,000.00	2,782,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,098,209.58	39,020,652.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,843,184.58	25,470,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,785,600.00	1,785,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,900.00	60,900.00
210807	Газрын төлбөр	65,325.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,211,700.00	9,088,190.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	573,500.00	2,000,497.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	742,200.00	1,997,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,200.00	1,997,100.00

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,985,792,012.25	130,826,784,285.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,099,105,590.72	76,782,581,521.21
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	71,954,099,205.57	76,441,289,761.59
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,683,500.00	7,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,967,085.15	318,275,359.62
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,355,800.00	15,516,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,886,686,421.53	54,044,202,764.11
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,886,686,421.53	54,044,202,764.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,664,894,718.14</u>	<u>3,052,338,268.41</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,664,894,718.14	3,052,338,268.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,905,678,745.64	8,570,573,463.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,570,573,463.78	11,622,911,732.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,386,834,900.00	77,318,267,640.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,386,834,900.00	77,318,267,640.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,016,500.00	853,961,478.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,154,100.00	650,540,007.57
210101	Үндсэн цалин	501,390,800.00	492,068,029.57
210102	Нэмэгдэл	121,923,300.00	123,700,378.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,320,000.00	23,321,600.00
210104	Урамшуулал	11,520,000.00	11,450,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,291,000.00	83,291,000.00
210201	Тэтгэврийн даатгал	57,662,900.00	57,662,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,407,000.00	6,407,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,125,600.00	5,125,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,281,400.00	1,281,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,814,100.00	12,814,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,667,900.00	42,244,866.00
210301	Гэрэл, цахилгаан	3,677,200.00	3,448,702.00
210302	Түлш, халаалт	37,377,600.00	37,377,560.00
210303	Цэвэр, бохир ус	1,613,100.00	1,418,604.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,736,600.00	33,585,850.00
210401	Бичиг хэрэг	7,437,100.00	7,437,100.00
210402	Тээвэр, шатахуун	17,887,900.00	17,887,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,231,600.00	5,172,470.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,000.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,498,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,790,700.00	2,782,500.00
210702	Дотоод албан томилолт	2,790,700.00	2,782,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,876,200.00	37,020,155.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,750,400.00	25,470,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,785,600.00	1,785,600.00

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,900.00	60,900.00
210807	Газрын төлбөр	65,400.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,663,900.00	9,088,190.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,997,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,997,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,523,818,400.00	76,464,306,161.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,523,818,400.00	76,464,306,161.59
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	77,500,802,000.00	76,441,289,761.59
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,516,400.00	15,516,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,386,834,900.00	31,478,514,986.05
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,140,648,500.00	59,067,320.45
310001	Улсын төсвөөс санхүүжих	14,140,648,500.00	59,067,320.45
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,246,186,400.00	31,381,651,566.94
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	64,246,186,400.00	31,381,651,566.94
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	37,796,098.66
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	36,950,935.82
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	845,162.84
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	8,570,573,463.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	11,622,911,732.19
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	109	107
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54	53
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	48	47
620003	Үйлчлэх ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	54	53
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	49	48
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		485,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	485,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		485,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		285,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		200,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь тасгийн дарга, хяналтын 3 байцаагч нийт 4 орон тоотойгоор ажиллаж байна. Тайлант онд нийт 24 ажил төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого, үр дүнгийн тайлангийн нийт орлогын 135,546,854.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,033,202.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,626,562.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 2,019,550.9 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 13,651.8 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 1,615,640.7 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нийгмийн даатгалын салбарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 38,147,525.1 мянган төгрөг, хүүгийн орлого 24,321.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 39,220.8 мянган төгрөг, бусад орлого 6,772.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 24,390.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 485.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 876,469.0 мянган төгрөг, дээд шатны захирагчаас 47,496,300.0 мянган төгрөг, дотоод төвлөрүүлэх шилжүүлэг 48,931,369.2 мянган төгрөг нийт 135,546,854.3 мянган төгрөг, өмнөх оноос 3,947,171.6 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Энэ нь нийгмийн даатгалын сан болон улсын төсвөөс авсан санхүүжилт буурсантай холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 131,349,183.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 131,683,231.2 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 77,318,274.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн санд 10, арилжааны банкинд 321 ширхэг харилцах данстай бөгөөд дансны үлдэгдэл оны эхэнд 8,570,573.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 11,622,911.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,570,573.4	11,622,911.7	3,052,338.2
Авлага	5,143,701.6	6,706,127.9	1,562,426.3
Урьдчилгаа			
Бараа материал	23,145.2	14,339.4	-8,805.8
Үндсэн хөрөнгө	584,040.9	574,144.5	-9,896.4
Нийт хөрөнгө	14,321,461.3	18,917,523.7	4,596,062.4
Өр төлбөр	699,523.7	1,086,241.4	386,717.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	13,621,937.5	17,831,282.2	4,209,344.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,321,461.3	18,917,523.7	4,596,062.4

Авлага, өглөгийн хэмжээ нэмэгдсэн нь гурав хүртэл насны хүүхдээ асарч буй эхчүүдийн улсын төсвөөс төлөх болон тэтгэмжийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн тооцоотой холбоотой 178,100.0 мянган төгрөгийг сумдад сангуудын бусад авлага, Зуунмод суманд сангуудын бусад өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,339.4 мянган төгрөг болж 8,805.8 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал данснаас хассанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 574,144.5 мянган төгрөг болж 9,896.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө дахин үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь НДЕГ-аас шилжиж ирсэн 5,589.2 мянган төгрөг, дахин үнэлж бүртгэсэн 24,390.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 21,738.2 мянган төгрөг, дахин үнэлж данснаас хассан 82,683.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,831,282.2 мянган төгрөг болж 4,209,344.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд шимтгэл хураамжийн орлогоор 24,522,259.56 мянган төгрөг, үйл ажиллагаанд 1,078,848.2 мянган төгрөг нийт 25,601,107.7 мянган төгрөг, нийт зарлагыг тэтгэвэр, тэтгэмжид 88,416,242.63 мянган төгрөг, үйл ажиллагаанд 1,078,848.2 мянган төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын хүргүүлсэн төсвийн төслөөс 11,108,255.93 мянган төгрөгөөр бууруулж 78,386,834.9 мянган төгрөг баталсан байна. Энэ нь сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг 10,831,317.43 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг 219,829.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 78,386,834.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 14,140,648.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 64,246,186.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 59,067.3 мянган төгрөгийн санхүүжилт, нийгмийн даатгалын сангаас 31,381,651.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 37,796.1 мянган төгрөг нийт 31,478,514.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 77,318,267.6 мянган төгрөгийг зарцуулж, 315.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 77,318,267.6 мянган төгрөг буюу 98,6 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс тайлант онд НДЕГ-аас 285.0 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 200.0 мянган төгрөг нийт 485.0 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дүгээр сарын 30-ний өдрийн 704 дугаар тогтоолоор 82,683.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасаж, 24,390.7 мянган төгрөгөөр 1-7 жилийн хугацаатайгаар ашиглах жилийн хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант онд нийт 4,546.4 мянган төгрөгийн цалингийн гүйлгээг төрийн албаны цалингийн нэгдсэн системээр хийлгүй ажилтны хувийн данс болон арилжааны банкаар дамжуулан олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Нийгмийн даатгалын сан нь нийт 1032 харилцагчтай холбоотой он дамжсан 67,643.5 мянган төгрөгийн өглөг, 118,686.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх арилжааны 37, төрийн сангийн 3, нийт 40 харилцах дансанд дахь 12,783.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст холбогдох сангуудад тогтоосон хувь хэмжээгээр хуваарилаагүй, үлдэгдэлтэй гарсан байна.

Татаас санхүүжилтийн болон төлбөртэй үйлчилгээний авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, огт мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бусад өглөг, авлагатай холбоотой албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 458 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлага, өглөгийн бүртгэлийн талаар дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 208,545.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 зөрчилд зөвлөмж өгч, 208,545.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага бичив.

4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 7,397.8 мянган төгрөгөөр дутуу, 2,034.8 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу Албан шаардлага хүргүүлэв.

Орлого төвлөрүүлэх арилжааны 37, төрийн сангийн 3, нийт 40 харилцах дансанд дахь 12,783.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст холбогдох сангуудад тогтоосон хувь хэмжээгээр хуваарилаагүй, үлдэгдэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4/-т "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл /зарлагаас давсан орлого/-ийг тухайн сан бүрийн нийгмийн даатгалын төв байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Тухайн сангийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа сард шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын төв байгууллагаас зөвшөөрөл авна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль

тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу Албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд нийт 1032 харилцагчтай холбоотой он дамжсан 67,643.5 мянган төгрөгийн өглөг, 118,686.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7 “Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үйл ажиллагааны санхүүгийн тайланг бэлтгэж байгаа "Санхүү" программ нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан заавар журамд нийцээгүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, мэдээллийг бүрэн тайлагнахгүй, алдаатай илэрхийлж байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын дагуу эрх бүхий байгууллагаар хянагдаж зөвшөөрөл авсан санхүүгийн программыг ашиглах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн НДСан	4	208,545.4					3	208,545.4	1	0